

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-10

1. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг чөлөөлөх, гишүүнээр томилох тухай асуудал 4-6

2. Байнгын хорооны тогтоолын төсөл /Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай/ 6-7

3. Байнгын хорооны тогтоолын төсөл /Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай/ 7-10

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 17 цаг 25 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, С.Бямбацогт, Г.Ганболд;
Чөлөөтэй: С.Амарсайхан, Ж.Батсуурь, Ё.Баатарбилэг, Т.Доржханд,
Б.Пүрэвдорж;
Эмнэлгийн чөлөөтэй: М.Оюунчимэг.

Нэг.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг чөлөөлөх, гишүүнээр томилох тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан, Цагдаагийн ерөнхий газрын дарга Т.Сүхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референт А.Наранцэцэг, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигчтэй хийсэн нэр дэвшигчийн сонголын тайланг сонгогч даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар танилцуулав.

Сонголын тайлан болон нэр дэвшигчидтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.

Н.Энхболд: Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн Б.Ганбатыг үүрэгт ажлаас нь чөлөөлөхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Н.Энхболд: Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн Ж.Болдыг үүрэгт ажлаас нь чөлөөлөхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Н.Энхболд: Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр Д.Дэлгэрсайханыг томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Н.Энхболд: Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр Т.Сүхболдыг томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референт А.Наранцэцэг, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд “Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.

Н.Энхболд: “Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 17 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референт А.Наранцэцэг, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд “Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.

Н.Энхболд: “Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 17 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 27 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 17 цаг 52 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
17 цаг 25 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Энхболд: Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, бүртгэлдээ орсон байна. Ирц бүрдсэн тул 2024 оны 1 сарын 2-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Гишүүддээ шинэ оны ажлын эхний өдрийн мэнд хүргэе. Шинэ онд ажил үйлс нь өөдрөг, бие нь эрүүл, амжилт бүтээл арвин байхын ерөөл дэвшүүлье. Хэлэлцэх асуудлаа танилцуулъя. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг чөлөөлөх, гишүүнээр томилох тухай асуудал байна. Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай Байнгын хорооны тогтоол хэлэлцэнэ. Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай Байнгын хорооны тогтоолын төсөл хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудал дээр саналтай хүмүүс байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг чөлөөлөх, гишүүнээр томилох тухай асуудал

СЕХ-ны гишүүнийг чөлөөлөх, гишүүнээр томилох тухай асуудлыг хэлэлцэнэ. Өнөөдөр бид нар, энэ чинь юу нь зүгээр юм бичээд явчихсан байх юм сонсголын тайлан гээд. Гишүүнийг чөлөөлөхөд чинь хамаагүй шүү дээ эхнийх нь. Хүлээж байгаарай. Нэр дэвшигч

нараа оруулчихъя Сонгуулийн ерөнхий хороонд. Явуулсан уу нөгөө хоёроо, байгаа юу? СЕХ-нд Дагвадоржийн Дэлгэрсайхан Бүртгэлийн ерөнхий газрын дарга, Төмөрбаатарын Сүхболд нар нэр дэвшсэн ТББХ-ноос дэвшүүлсэн. Урьд нь СЕХ-нд ажиллаж байсан гишүүд хуулийн дагуу өргөдлөө өгөөд, ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан учраас Байнгын хорооноос холбогдох шалгуур үзүүлэлтүүдийн дагуу, ажлын шаардлагын дагуу энэ 2 хүнийг нэрийг нь дэвшүүлсэн байгаа. Өнөөдөр ТББХ хуралдаж сонсголоо явуулсан. Сонсголыг Сүхбаатар гишүүн удирдаж явуулсан. Дараа нь хаалттай хуралдаан хийж, сонсголын тайлан гаргасан. Тайлан гишүүдэд танилцуулсан байгаа. Тайлан нэр дэвшигчтэй холбогдуулж асуулт асуух, үг хэлэх гишүүн байна уу? Сонсголын тайлангаа сонсгол удирдсан Сүхбаатар гишүүн танилцуулна. Сүхбаатар гишүүний микрофоныг өгөхийг хүсье.

Ж.Сүхбаатар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

СЕХ-ны гишүүнд нэр дэвшигч нартай хийсэн нэр дэвшигчийн сонсголыг Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлд 4.1 хороо нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 2 нь орон тооны, 7 нь орон тооны бус байна. 4.2 хорооны гишүүний 5-ыг Улсын Их Хурлын ТББХ, 2-ыг Монгол Улсын Ерөнхийлөгч, 2-ыг Улсын дээд шүүх төрийн жинхэнэ албан хаагчдаас санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж, 6 жилийн хугацаагаар томилно. 4.5 хорооны гишүүний бүрэн эрх нь түүнийг томилсон тухай Улсын Их Хурлын шийдвэр гарснаар эхэлж, дараагийн гишүүн томилогдсоноор дуусгавар болно гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн нэр дэвшигчийн сонсголын үе шатыг баримтлан дараах ажиллагааг явууллаа.

1. Улсын Их Хурлын ТББХ-ноос нэр дэвшүүлсэн *Дагвадоржийн Дэлгэрсайхан, Төмөрбаатарын Сүхболд* нар нь ТББХ-ны 2022 оны 15 дугаар тогтоолоор баталсан нэр дэвших тухай хүсэлтийн загварын дагуу материал бүрдүүлж, Байнгын хороонд ирүүлсэн болно.

2. 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-д заасны дагуу нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай тогтоолыг баталж, 2024 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар, сонсгол даргалагчаар Их Хурлын гишүүн *Жамъянхорлоогийн Сүхбаатарыг* томилсон.

Сонсголыг бэлтгэх бэлтгэл хангах хүрээнд нэр дэвшигчийн мэдээллийг *parliament.mn* буюу Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулсан. Сонсголын тов хугацаа, сонсголд оролцогчдын бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, *itoim.mn, ikon.mn, 24tsag.mn, livetv.mn, neguun.mn, news.mn, newspress.mn, times.mn, tovch.mn, zarig.mn, mgl88.3 fm* радио зэргээр 19 хоногийн хугацаанд давтамжтай байршуулсан. Мэдээллийн дагуу нэг оролцогч бүртгүүлснийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороо хүсэлтийг хүлээн авсан огноо, цаг, минутаар бүртгэж баталгаажуулсан.

4. 2024 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн 14 цагт ТББХ-ны гишүүдийн 1/3-ээс доошгүй нь хүрэлцэн ирснээр ирц бүрдэх бөгөөд Байнгын хорооны сонсголд Улсын Их Хурлын гишүүн *Г.Занданшатар, Д.Тогтохсүрэн, Б.Жаргалмаа, Ц.Мөнхцэцэг,*

Д.Сарангэрэл, Ж.Сүхбаатар, Н.Энхболд нар хүрэлцэн ирж, ирц бүрдэж, нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулсан болно. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 127 дугаар зүйлд заасны дагуу сонсголд оролцсон гишүүд сонсгол явуулснаас хойш 2 өдрийн дотор хаалттай хуралдаанд, хаалттай хуралдаж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайлан гаргана. Тайлан сонсголын дүнд үндэслэн тухайн нэр дэвшигч албан тушаалд шаардлага хангасан эсэх дүгнэлт, түүний үндэслэлийг тусгана. Тухайн тайланг ажлын 5 өдрийн дотор нэр дэвшигч түүний санал болгосон этгээдэд хүргүүлж, парламентын цахим хуудаст байршуулж болно гэсний дагуу 2024 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсох сонсголын тайланг гаргалаа, батлан гаргалаа.

Нэр дэвшигчийн сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч *Дагвадоржийн Дэлгэрсайхан, Төмөрбаатарын Сүхболд* нарыг ирүүлсэн материал болон сонсголын үр дүнд үндэслэн СЕХ-ны гишүүнд тавигдах шаардлагыг хангасан гэж үзэн хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжлээ. Монгол Улсын Их Хурлын, Монгол Улсын Их Хуралд СЕХ-ны гишүүнд санал болгосон нэр дэвшигчийн талаарх сонсголын тайланг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Энхболд: Тайлан болоод нэр дэвшигчидтэй холбогдуулж асуух гишүүн байвал нэрээ өгье. Алга байна. Үг хэлэх гишүүн байна уу? Алга, сая ч бид нар нэлээн дэлгэрэнгүй ярьчихсан даа. Тэгвэл санал хурааж эхэлнэ.

Эхлээд СЕХ-ны гишүүнээс чөлөөлье гэсэн саналаар санал хураалт явуулна. Санал хураалтыг Дэгийн тухай хуулийн 14.2-ын дагуу нэг, нэг хүн байгаа

учраас гараа өргөөд явуулчихъя, хураачихъя. Ер нь болбол 14.2-оор ил санал хураалтыг цахимаар эсхүл гар өргөж явуулна гэсэн ийм заалт байгаа. Энэний дагуу илээр гараа өргөөд санал хураалтаа явуулчихъя. СЕХ-ны гишүүн Бямбажавын Ганбатыг СЕХ-ны гишүүнээс чөлөөлье гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. 3, 4, 6. 10-аас 6 хүн дэмжлээ. СЕХ-ны гишүүн Жамсранжавын Болдыг СЕХ-ны гишүүнээс чөлөөлье гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт 1, 2, 3, 4, 5, 6 хүн дэмжлээ.

Дараа нь Дагвадоржийн Дэлгэрсайханыг СЕХ-ны гишүүнээр томилуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 6 хүн дэмжиж олонхын саналаар дэмжлээ. Төмөрбаатарын Сүхболдыг СЕХ-ны гишүүнээр томилуулах саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 6 хүн, 10-аас 6 санал хураалт дэмжигдлээ.

Тогтоолын төсөл танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын тогтоол СЕХ-ны гишүүнээр гишүүнээс гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108.2 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.5 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь. СЕХ-ны гишүүнээр Дагвадоржийн Дэлгэрсайхан, Төмөрбаатарын Сүхболд нарыг томилсугай.

2.Өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Бямбажавын Ганбат, Жамсранжавын Болд нарыг СЕХ-ны гишүүнээс чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй. Тогтоолын төслийг танилцууллаа, дэмжье гэсэн. Чуулганд, түрүүн чинь бид нар гараа өргөчихсөн тийм ээ. Чуулганы

хуралдаанд Сүхбаатар гишүүн Байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулна. Баярлалаа.

17.36 цаг

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай/

Дараагийн асуудалдаа оръё. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ. Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя. Үндэсний зөвлөл 15 гишүүнтэй байдаг. Тодорхой субъектүүдээс нэрийг нь дэвшүүлдэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүн Дуламрагчаагийн Жавзандорж Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлт ирүүлсэн тул Үндэсний зөвлөлийн гишүүний албан тушаалд Ноовойн Нанзаддоржийн нэрийг дэвшүүлж байна. Зохих журмын дагуу шийдвэрлэж өгнө үү. Монгол Улсын Ерөнхийлөгч Хүрэлсүх гэсэн ийм албан бичиг 23 оны 12 сарын 28-ны өдөр, Е17 тоот бичгээр ирсэн.

Жавзандорж Үндэсний зөвлөлийн гишүүн Жавзандорж Хамба ламтнаар сонгогдсон. Ингээд хуулийн дагуу эрхийнхээ дагуу Ерөнхийлөгч Ноовойн Нанзаддоржийн нэрийг дэвшүүлж ирүүлсэн байна. Тогтоолын төсөл нь. Ерөнхийлөгчөөс нэр дэвшүүлж байгаа. Болжуухай ургийн овогтой Ноовойн Нанзаддорж 73 онд төрсөн. Улаанбаатар хотод төрсөн. Монгол Улсын, Монгол Улсад 47 дугаар сургуулийг 81-ээс 90 онд суралцаж төгсөж, дунд боловсрол эзэмшсэн. БНЭУ-ын Goman Monastery University-д

1995-аас 2000 онд суралцаж, Парчин дамжаа гэдэг мэргэжил эзэмшсэн. Мөн БНЭУ-ын Goman сүмийн их сургуульд 2000-аас 2002 онд сурч Зод дамжааг дүүргэсэн. Мөн сургуулийнхаа Умын дамжааг 2002-оос 2004 онд сурч төгсгөсөн. Монголын Бурхан Шашинтны Төв Гандантэгчэнлин хийд Даичойнпэл дацан сургуульд 2 мянга, 1991-ээс 2008 онд ажилласан, гавж цолтой. Ийм хүнийг нэрийг нь дэвшүүлж ирүүлсэн байна.

Үүнтэй холбогдуулаад Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулъя. Олон нийтийн, Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.1 дэх хэсэг, 119 дүгээр зүйлийн 119.1 дэх хэсэг, Нийтийн сонсголын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29.1 дэх хэсэг, Олон улсын радио, телевизийн тухай хуулийн, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТББХ-ноос тогтоох нь.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлсэн Ноовойн Нанзаддоржтой хийх нэр дэвшигчдийн сонсголыг 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

2.Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Сарангэрэлийг томилсугай.

3.Нэр дэвшигчид хандан асуух асуулт, саналыг 2024 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл хүлээн авахаар тогтоосугай.

4.Нэр дэвшигчийн сонсголын зарыг нийтэд мэдээлж, бэлтгэл ажлыг хангаж, холбогдох хууль журамд заасны дагуу зохион байгуулахыг ТББХ Энхболдод даалгасугай гэсэн ийм тогтоолын төсөл байна. Нэр дэвшигчтэй холбогдуулж нэр дэвшигчээс үүн дээр, Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуух гишүүн байна уу? Алга байна. Үг хэлэх гишүүн байна уу? Алга байна.

Тэгвэл Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай Байнгын хорооны тогтоол төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт, түрүүн хэлэлцсэнийхээ дагуу илээр санал хураагаад гар өргөж хураая. Саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Сүхбаатар гишүүн дэмжиж байна уу? Дэмжиж байгаа юм байна. 10 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж Байнгын хорооны тогтоолыг баталлаа. Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнээр нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж шийдвэрлэлээ.

17.36 цаг

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай/

Дараагийн асуудалд орёе. ТАЗ-ийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол

даргалагчийг тогтоох тухай Байнгын хорооны тогтоолыг хэлэлцэж эхэллээ. Тогтоолын төслийг та бүхэнд танилцуулъя. 2 хүний асуудал яригдаж байгаа. Бүрэн эрхийн хугацаа нь дуусаад нэг нь ЗГ-аас нэрийг нь дэвшүүлсэн, нөгөөх нь Улсын Их Хурлаас нэрийг нь дэвшүүлсэн 2 хүн байгаа. Ингээд Монгол Улсын ЗГ-аас 23 онд ирүүлсэн саналын дагуу асуудлыг хэлэлцэнэ. Монгол Улсын ЗГ санал хүргүүлэх тухай. Лхагвын Цэдэвсүрэнг ТАЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэн томилуулах саналыг Улсын Их Хуралд хүргүүлж байна. Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлэж өгнө үү. Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ гэсэн санал ирсэн.

ТАЗ-ийн орон тооны гишүүнээр ажиллаж байсан Самдангийн Цэдэндамбын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан Төрийн албаны тухай хуулийн 68.2-т заасныг үндэслэн ЗГХЭГ-аас тус зөвлөлийн гишүүний сул орон тоонд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтыг 2023 оны 1 сарын 4-ний өдөр олон нийтийн сүлжээгээр нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтын зарыг өөрийн албан ёсны цахим хуудсанд байршуулсан. ЗГХЭГ-ын цахим шуудангаар нийт 9 нэр дэвшигчийн материалыг хүлээн авсан бөгөөд нэг нэр дэвшигч өөрийн хүсэлтээр нэрээ татан авсан. Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын даргын 2022 оны 2 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг хуулийн хүрээнд 8 нэр дэвшигчийн материалыг хянан үзэхэд бүгд хуульд заасан шаардлагыг хангасан байсан тул нэр дэвшигчийн ажлын туршилагад үндэслэн Лхагвын Цэдэвсүрэнг ТАЗ-ийн орон тооны гишүүнд нэр дэвшүүлэн танилцуулж байна.

Лхагвын Цэдэвсүрэн 1967 онд Говь-Алтай аймгийн Алтай хотод төрсөн, 56 настай. 1985 онд ерөнхий боловсролын 13 дугаар дунд сургууль, 1994 онд МУИС-ийн Хууль зүйн сургууль төгссөн, эрх зүйч мэргэжилтэй. 1985-

аас 87 онд Хотын барилга засварын нэгдсэн трестэд ажилтан, 1994-өөс 96 онд Соёлын яамны Тамгын газарт хуулийн зөвлөх, 96-аас 2000 онд Гэгээрлийн яамны Төрийн захиргааны газарт сайдын туслах, хуулийн зөвлөх, 2000-аас 2009 онд БСШУЯ-ны Төрийн захиргаа, хамтын ажиллагааны газарт хуулийн зөвлөх, мэргэжилтэн, хэлтсийн дарга, газрын дарга, 2009-өөс 2014 онд БШУЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, 2014-өөс 20 онд БСШУСЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Хуулийн хэлтсийн дарга, Төрийн нарийн бичгийн дарга, 2020-оос 21 онд Боловсрол, шинжлэх ухааны сайд, 2021 оны 2-оос 10 дугаар сард Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, 21 оны 10 сараас өнөөдрийг хүртэл Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны ТНБД-аар тус тус ажиллаж байгаа ийм хүн байна.

Монгол Улсын Их Хурлаас нэр дэвшүүлэх хүнд Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар нэр дэвшүүлж ирүүлсэн. Нэр дэвшүүлэх тухай. Төрийн албаны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.2 дахь хэсэгт зөвлөлийн гишүүнд Улсын Их Хурлын Тамгын газар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тус бүр 1 хүний, төрийн албан хаагчийн төлөөлөл 2 хүнийг нэр дэвшүүлэх бөгөөд нэр дэвшигч нь төрийн жинхэнэ албанд 15-аас доошгүй жил ажилласан, төрийн удирдлага, эдийн засаг, эрх зүй, боловсролын чиглэлээр мэргэшсэн, дээд боловсролтой, ял шийтгүүлж байгаагүй, 45 нас хүрсэн, Монгол Улсын иргэн байна гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас нэр дэвшүүлж томилсон ТАЗ-ийн гишүүн Баатарзоригийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон тул дээр дурдсан хуулийн шаардлага хангасан Улсын Их Хурлын Тамгын газрын Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга Баяр овогтой Пүрэвдагвыг ТАЗ-ийн гишүүнээр томилуулахаар нэр дэвшүүлж,

танилцуулга, холбогдох бусад материалыг хүргүүлж байна. Зохих журмын дагуу хэлэлцэж шийдвэрлэж өгнө үү. Ерөнхий нарийн бичгийн дарга Энхбат гэсэн бичиг ирсэн байна.

Баяр овогтой Пүрэвдагвын ажил байдлын тодорхойлолт, танилцуулгыг та бүхэнд толилуулъя. Б.Пүрэвдагва 74 онд Улаанбаатар хотод төрсөн, 45 настай, эхнэр хүүхэд, 49 настай, эхнэр хүүхдүүдийн хамт амьдардаг. Боловсролын докторант, эрх зүйч мэргэжилтэй. Улсад 25 жил үүнээс төрийн албаны жинхэнэ албан тушаалд төрийн жинхэнэ албан тушаалд 21 жил ажилласан. 1996-аас 2000 онд Түшээ хууль зүйн сургуульд суралцаж эрх зүйч мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн. 2006-аас 2008 онд ЗГ-ын хэрэгжүүлэх агентлаг Удирдлагын академид удирдлагын ухааны чиглэлээр суралцаж магистрын зэрэг хамгаалсан. 2001-ээс 2005 онд Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газарт тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан зохион байгуулагч, хороо хариуцсан зохион байгуулагч, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн. 2005-аас 2005 онд Хан-Уул дүүргийн ЗДТГ хуулийн зөвлөхөөр, 2005-аас 13 онд Нийслэлийн боловсролын газар хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга, даргаар ажилласан. 2013-аас 16 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын алба хүний нөөц хариуцсан референт, ахлах референт, Төрийн албаны зөвлөлийн салбарын зөвлөлийн нарийн бичгийн дарга, 2017-гоос 19 онд Улсын Их Хурлын Тамгын газарт ахлах зөвлөх, ахлах референт, 2019-өөс 2023 онд Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба ахлах референт, Хүний нөөцийн удирдлага, аудитын газрын даргаар ажилласан. 2023 оноос одоог хүртэл Улсын Их Хурлын Тамгын газар Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн даргаар ажиллаж байгаа. Ийм хүмүүсийн нэрийг дэвшүүлж ирүүлсэн.

Байнгын хорооноос бид нар тогтоол гаргах ёстой. Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол. Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.1 дэх хэсэг, 119 дүгээр зүйлийн 119.1 дэх хэсэг, Нийтийн сонсголын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТББХ-ноос тогтоох нь.

ТАЗ-ийн гишүүнд нэр дэвшигч Лхагвын Цэдэвсүрэн, Баярын Пүрэвдагва нартай хийх нэр дэвшигчийн сонсголыг 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

2.ТАЗ-ийн гишүүнд нэр дэвшигч нартай хийх нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийг томилсугай.

Нэр дэвшигчид хандан асуулт асуух, асуух асуулт, саналыг 2024 оны 1 сарын 15-ны өдрийг хүртэл хүлээн авахаар тогтоосугай. Нэр дэвшигчийн сонсголын зарыг нийтэд мэдээлж, бэлтгэл ажлыг хангаж, холбогдох хууль журамд заасны дагуу зохион байгуулахыг ТББХ Энхболдод даалгасугай гэсэн төсөл байна. Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух гишүүн байна уу? Алга байна. Үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Олон нийтийн, Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай Байнгын хорооны тогтоолыг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

Түрүүчийн дэгээрээ илээр гар өргөж, санал хураалт явуулна. Санал хураалт. 1, 2, 3, 4, 5, 6, 7. 10 гишүүн хуралдаанд оролцож, 7 гишүүн дэмжиж, Байнгын хорооны тогтоол батлагдлаа. Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдээ хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай Байнгын хорооны санал тогтоолыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

17.52 цаг

Өнөөдрийн байнгын хороогоор хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдаан хаасныг мэдэгдье. Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА

